ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДУА-2025/30/НА-СТА-ТШЗ**

---

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ
Утас: 70592225
Цахим хаяг: Oyunerdenet@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Батсайхан
Утас: 70593113
Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn

Аудитор: Ж.Угтахбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

**0**

**1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ....2**
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ....4**
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....4**
**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....5**
**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....6**
**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....8**
**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....8**
**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....10**
**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....11**
**3.1 Төлбөрийн акт....11**
**3.2 Албан шаардлага....11**
**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ....16**

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208, 70593208, Цахим хаяг; dundgovi@audit.gov.mn

2025.02.24 № 18

танай ____________ -ны № ____________ -т

**ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Н.ТҮВШИНЖАРГАЛ ТАНАА**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар төсвөөс гаргах баяр наадмын зардлыг санхүүжилтийн жишиг дээд хэмжээнээс хэтрүүлэн зарцуулсан, төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй, шатахууны зардлыг хяналтгүй зарцуулсан зэрэг 227.7 сая төгрөгийн материаллаг зөрчил нь тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 8.8 дахин их байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6.4.1, 16.5.2, 45.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, Засгийн газрын 2010 оны 271 дугаар тогтоолын "Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай /наадмын санхүүжилт/"-ийн 1-д заасан заалтуудтай нийцэхгүй, эрх ба үүрэг, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 сарын сарын 01-ээр төрийн албаны үндсэн цалин нэмсэн, бүх төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг олгож эхэлсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 2.1 дахин өссөн байна. Мөн орон нутагт тогтвор суурьшилтай 5 жил ажилласны тэтгэмжийг төрийн захиргааны албан хаагчдад олгож эхэлснээр 2024 онд 1 албан хаагч 9.1 сая төгрөгийн

4825020061

дэмжлэг авсан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

**Аудитын гол асуудал**

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд санхүүгийн албан хаагчдад ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр балансын урамшууллыг үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон нь тайлант үеийн өндөр үнэлэгдсэн эрсдэлтэй асуудал байлаа.

**Бусад асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилт, 67 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 91.3 хувьтай үнэлэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 350,059,790.94 | 352,580,890.94 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 8,725,887.44 | 9,375,487.44 |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | | |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 8,725,887.44 | 9,375,487.44 |
| 3121 | Төгрөг | 8,725,887.44 | 9,375,487.44 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 8,725,887.44 | 9,375,487.44 |
| 314 | Замд яваа мөнгөн хөрөнгө | | |
| 33 | АВЛАГА | 33,988.34 | 33,988.34 |
| 331 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 15,817.00 | 15,817.00 |
| 335 | Бусад авлага | 18,171.34 | 18,171.34 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 2,000.00 | 2,000.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 16,171.34 | 16,171.34 |
| 34 | УРЬДЧИЛГАА | | |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 264,809,915.16 | 266,681,415.16 |
| 351 | Түүхий эд материал | 12,259,500.00 | 12,259,500.00 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | 12,259,500.00 | 12,259,500.00 |
| 354 | Хангамжийн материал | 121,136,415.16 | 123,007,915.16 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 5,882,300.00 | 7,722,200.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 102,824,715.16 | 102,856,315.16 |
| 3543 | Сэлбэг хэрэгсэл | 7,100,000.00 | 7,100,000.00 |
| 3545 | Барилгын засварын материал | 5,329,400.00 | 5,329,400.00 |
| 356 | Мал амьтад | 131,414,000.00 | 131,414,000.00 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 76,490,000.00 | 76,490,000.00 |
| 369 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/ | 76,490,000.00 | 76,490,000.00 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,797,003,318.98 | 2,762,871,798.74 |
| 37 | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | | |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,797,003,318.98 | 2,762,871,798.74 |
| 392 | Биет хөрөнгө | 2,601,388,356.52 | 2,550,544,161.24 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,783,891,753.77 | 2,815,541,753.77 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -585,937,543.44 | -728,614,484.18 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 249,808,533.44 | 339,395,533.44 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -72,707,723.36 | -88,267,314.96 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 264,814,098.00 | 268,452,498.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -90,837,736.44 | -111,537,928.77 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 71,633,718.00 | 63,389,790.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -41,341,528.81 | -38,920,276.25 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 27,821,860.00 | 41,994,660.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -5,757,074.64 | -10,890,069.81 |
| 393 | Биет бус хөрөнгө | 195,614,962.46 | 212,327,637.50 |
| 39301 | Програм хангамж | 7,406,625.00 | 7,406,625.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -2,768,662.54 | -4,055,987.50 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 190,977,000.00 | 208,977,000.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 3,147,063,109.92 | 3,115,452,689.68 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 672,066.00 | |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 672,066.00 | |
| 413 | Өглөг | 672,066.00 | |
| 4131 | Ажилчидтай холбогдсон өглөг | 441,416.00 | |
| 4132 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 144,150.00 | |
| 4136 | Бусад өглөг | 86,500.00 | |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 86,500.00 | |
| 414 | Урьдчилж орсон орлого | | |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | |
| 422 | Урт хугацаат зээл | | |

| | | | |
|---|---|---|---|
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 3,146,391,043.92 | 3,115,452,689.68 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,146,391,043.92 | 3,115,452,689.68 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 642,447,254.10 | 642,447,254.10 |
| 5E+05 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | | |
| 5E+05 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 642,447,254.10 | 642,447,254.10 |
| 51101 | Өмч: - төрийн | | |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 2,396,506,716.84 | 2,365,568,362.60 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 2,396,506,716.84 | 2,397,034,632.84 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | -31,466,270.24 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 107,437,072.98 | 107,437,072.98 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 3,147,063,109.92 | 3,115,452,689.68 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,012,887,080.26 | 2,602,228,741.78 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 51,203,013.88 | 212,924,246.40 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 51,203,013.88 | 212,924,246.40 |
| 120001 | Хувьцааны ногдол ашиг | 2,170,600.00 | |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 8,751,887.44 | 8,000,000.00 |
| 1E+06 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,751,887.44 | 8,000,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 40,280,526.44 | 167,522,800.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 37,401,446.40 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 961,684,066.38 | 2,389,304,495.38 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 10,281,566.38 | 143,317,595.38 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 31,094,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,814,521.00 | 69,602,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 8,467,045.38 | 42,620,295.38 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 951,402,500.00 | 2,245,986,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 951,402,500.00 | 2,245,986,900.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 676,962,950.91 | 2,595,808,792.79 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 676,962,950.91 | 2,595,808,792.79 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 675,512,950.91 | 2,155,063,544.17 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 332,496,615.27 | 1,000,344,237.84 |
| 210101 | Үндсэн цалин | 235,205,449.55 | 512,264,397.50 |
| 210102 | Нэмэгдэл | 77,434,166.52 | 299,076,034.42 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,175,000.00 | 33,115,000.00 |
| 210104 | Урамшуулал | 9,681,999.20 | 17,247,700.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 138,641,105.92 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 55,944,086.67 | 123,670,868.71 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 40,244,123.48 | 86,817,127.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,171,274.08 | 10,213,779.73 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,416,225.57 | 4,994,689.84 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 694,946.31 | 4,329,051.30 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,417,517.23 | 17,316,219.95 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 39,023,443.77 | 93,675,958.73 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,436,905.77 | 7,067,688.73 |
| 210302 | Түлш, халаалт | 31,959,550.00 | 84,120,770.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,626,988.00 | 2,487,500.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 85,052,273.10 | 70,350,241.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 4,518,200.00 | 6,857,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 36,826,709.10 | 55,183,150.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,021,800.00 | 3,683,460.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,200,000.00 | 4,625,831.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 40,485,564.00 | |
| 2105 | Нормативт зардал | | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,549,200.00 | 14,774,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 230,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,549,200.00 | 14,544,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,886,000.00 | 4,520,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,886,000.00 | 4,520,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 62,202,768.37 | 108,346,644.48 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 61,964,940.37 | 103,969,115.68 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | 4,010,175.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 204,828.00 | 291,297.80 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 55,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 21,056.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 92,358,563.73 | 739,381,593.41 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 92,358,563.73 | 526,315,146.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 678,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 212,388,447.41 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,450,000.00 | 440,745,248.62 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,450,000.00 | 169,114,439.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | 8,000,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | 13,903,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 38,859,874.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 35,729,015.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,450,000.00 | 72,622,050.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | | 271,630,809.62 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 232,099,139.21 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 39,531,670.41 |
| | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | |
| | Дотоод эх үүсвэрээр | | |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 335,924,129.35 | 6,419,948.99 |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | | |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 37,886,219.23 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 484,772.83 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | | 37,401,446.40 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | | -37,886,219.23 |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 335,924,129.35 | -31,466,270.24 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 993,485,623.64 | 2,397,304,495.38 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 19,719,374.88 | 8,000,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 19,719,374.88 | 8,000,000.00 |
| 120001 | Хувьцааны ногдол ашиг | 2,215,600.00 | |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 17,503,774.88 | 8,000,000.00 |
| 1E+06 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,277,887.44 | 8,000,000.00 |
| 1E+06 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | 8,225,887.44 | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 973,766,248.76 | 2,389,304,495.38 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 20,563,132.76 | 143,317,595.38 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 31,094,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,629,042.00 | 69,602,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 16,934,090.76 | 42,620,295.38 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 951,402,500.00 | 2,245,986,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 951,402,500.00 | 2,245,986,900.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 1,800,616.00 | |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 1,800,616.00 | |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 857,817,041.61 | 2,385,435,995.38 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 857,817,041.61 | 2,385,435,995.38 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 856,367,041.61 | 1,944,730,746.76 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 463,217,759.54 | 1,000,344,237.84 |
| 210101 | Үндсэн цалин | 328,795,733.19 | 512,264,397.50 |
| 210102 | Нэмэгдэл | 108,135,027.15 | 299,076,034.42 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 16,605,000.00 | 33,115,000.00 |
| 210104 | Урамшуулал | 9,681,999.20 | 17,247,700.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 138,641,105.92 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 54,084,856.10 | 123,670,868.71 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,671,093.43 | 86,817,127.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,678,428.78 | 10,213,779.73 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,489,640.52 | 4,994,689.84 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 938,770.30 | 4,329,051.30 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,306,923.07 | 17,316,219.95 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 39,023,443.77 | 93,675,958.73 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,436,905.77 | 7,067,688.73 |
| 210302 | Түлш, халаалт | 31,959,550.00 | 84,120,770.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,626,988.00 | 2,487,500.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 41,358,989.10 | 54,283,601.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,377,800.00 | 8,336,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 32,957,999.10 | 37,072,460.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,021,800.00 | 3,683,460.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,001,390.00 | 5,190,781.00 |
| 2105 | Нормативт зардал | | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 47,353,100.00 | 14,774,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 36,980,490.00 | 230,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,372,610.00 | 14,544,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,886,000.00 | 4,520,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,886,000.00 | 4,520,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 57,957,768.37 | 108,074,644.48 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 57,059,940.37 | 103,697,115.68 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | 4,010,175.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 204,828.00 | 291,297.80 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 660,000.00 | |
| 210807 | Газрын төлбөр | | 21,056.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 149,485,124.73 | 545,387,436.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 149,397,624.73 | 544,709,436.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 87,500.00 | 678,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,450,000.00 | 440,705,248.62 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,450,000.00 | 169,074,439.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | 8,000,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | 13,903,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 38,819,874.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 35,729,015.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,450,000.00 | 72,622,050.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | | 271,630,809.62 |

| | | | |
|---|---|---|---|
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 232,099,139.21 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 39,531,670.41 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 135,668,582.03 | 11,868,500.00 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| IV | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4) | | |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | | 11,218,900.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | | 11,218,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 11,218,900.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | | -11,218,900.00 |
| 145 | Бусад эх үүсвэр | | |
| 25 | Санхүүгийн үйл ажиллагааны зардал | | |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 135,668,582.03 | 649,600.00 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 8,725,887.44 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 9,375,487.44 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 642,447,254.10 | 107,437,072.98 | 2,392,393,855.08 | 3,142,278,182.16 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| 7 | Тайлант үеийн үр дүн | | | 4,112,861.76 | 4,112,861.76 |
| 10 | 2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 642,447,254.10 | 107,437,072.98 | 2,396,506,716.84 | 3,146,391,043.92 |
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 527,916.00 | 527,916.00 |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | |
| 13 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| 14 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| 15 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| 16 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | |
| 17 | Тайлант үеийн үр дүн | | | -31,466,270.24 | -31,466,270.24 |
| 18 | . . . . . . . . . . . . . . . . | | | | |
| 19 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 642,447,254.10 | 107,437,072.98 | 2,365,568,362.60 | 3,115,452,689.68 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн |
|---|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,245,986,900.00 | 2,013,887,760.79 | 232,099,139.21 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,245,986,900.00 | 1,974,356,090.38 | 271,630,809.62 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,055,507,500.00 | 1,856,313,721.80 | 199,193,778.21 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,071,206,700.00 | 1,000,344,237.84 | 70,862,462.16 |
| 210101 | Үндсэн цалин | 538,870,500.00 | 512,264,397.50 | 26,606,102.50 |
| 210102 | Нэмэгдэл | 310,580,800.00 | 299,076,034.42 | 11,504,765.58 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 39,230,000.00 | 33,115,000.00 | 6,115,000.00 |
| 210104 | Урамшуулал | 42,551,600.00 | 17,247,700.00 | 25,303,900.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 139,973,800.00 | 138,641,105.92 | 1,332,694.08 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 134,189,200.00 | 123,670,868.71 | 10,518,331.29 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 91,248,600.00 | 86,817,127.89 | 4,431,472.11 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,735,100.00 | 10,213,779.73 | 521,320.27 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,367,600.00 | 4,994,689.84 | 372,910.16 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,367,600.00 | 4,329,051.30 | 1,038,548.70 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,470,300.00 | 17,316,219.95 | 4,154,080.05 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 107,424,800.00 | 92,404,173.76 | 15,020,626.24 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,000,000.00 | 6,484,679.76 | 515,320.24 |
| 210302 | Түлш, халаалт | 95,424,800.00 | 84,120,770.00 | 11,304,030.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,000,000.00 | 1,798,724.00 | 3,201,276.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 58,464,800.00 | 51,097,761.00 | 7,367,039.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,433,500.00 | 8,336,900.00 | 96,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 38,258,000.00 | 34,138,620.00 | 4,119,380.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,157,300.00 | 3,683,460.00 | 473,840.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 654,000.00 | | 654,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,962,000.00 | 4,938,781.00 | 2,023,219.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,286,800.00 | | 1,286,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,286,800.00 | | 1,286,800.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 38,500,000.00 | 25,992,900.00 | 12,507,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 13,500,000.00 | 11,448,900.00 | 2,051,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 25,000,000.00 | 14,544,000.00 | 10,456,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,600,000.00 | 4,236,000.00 | 1,364,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,600,000.00 | 4,236,000.00 | 1,364,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 39,910,400.00 | 33,180,344.48 | 6,730,055.52 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 32,979,400.00 | 28,802,815.68 | 4,176,584.32 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 4,916,000.00 | 4,010,175.00 | 905,825.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 528,000.00 | 291,297.80 | 236,702.20 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 283,000.00 | 55,000.00 | 228,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 694,000.00 | | 694,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 510,000.00 | 21,056.00 | 488,944.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 598,924,800.00 | 518,037,036.00 | 73,537,364.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 596,340,800.00 | 517,359,036.00 | 71,631,364.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,584,000.00 | 678,000.00 | 1,906,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 190,479,400.00 | 125,392,768.59 | 65,086,631.41 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 190,479,400.00 | 164,924,439.00 | 25,554,961.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 8,000,000.00 | 8,000,000.00 | |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 14,000,000.00 | 13,903,500.00 | 96,500.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 42,179,400.00 | 38,819,874.00 | 3,359,526.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 36,100,000.00 | 35,729,015.00 | 370,985.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 90,200,000.00 | 68,472,050.00 | 21,727,950.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох | | -39,531,670.41 | 39,531,670.41 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | | |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | -39,531,670.41 | 39,531,670.41 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | | |
| | Дотоод эх үүсвэрээр | | | |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,245,986,900.00 | 2,013,887,760.79 | 232,099,139.21 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | | | |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,245,986,900.00 | 2,013,887,760.79 | 232,099,139.21 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 2,245,986,900.00 | 2,013,887,760.79 | 232,099,139.21 |
| | | | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн |
|---|---|---|---|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 143,317,595.38 | -143,317,595.38 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | | 143,317,595.38 | -143,317,595.38 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 99,635,924.97 | -99,635,924.97 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | | |
| Үндсэн цалин | | | |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | | |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 1,271,784.97 | -1,271,784.97 |
| Гэрэл, цахилгаан | | 583,008.97 | -583,008.97 |
| Цэвэр, бохир ус | | 688,776.00 | -688,776.00 |
| Хангамж, бараа материалын зардал | | 3,185,840.00 | -3,185,840.00 |
| Тээвэр, шатахуун | | 2,933,840.00 | -2,933,840.00 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 252,000.00 | -252,000.00 |
| Нормативт зардал | | | |
| Эд хогшил, урсгал засварын зардал | | | |
| Томилолт, зочны зардал | | 284,000.00 | -284,000.00 |
| Дотоод албан томилолт | | 284,000.00 | -284,000.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 74,894,300.00 | -74,894,300.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 74,894,300.00 | -74,894,300.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | | 20,000,000.00 | -20,000,000.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | | 20,000,000.00 | -20,000,000.00 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 43,681,670.41 | -43,681,670.41 |
| Бусад урсгал шилжүүлэг | | 4,150,000.00 | -4,150,000.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 4,150,000.00 | -4,150,000.00 |
| Олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 39,531,670.41 | -39,531,670.41 |
| Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | | 39,531,670.41 | -39,531,670.41 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | | |
| Дотоод эх үүсвэрээр | | | |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 143,317,595.38 | -143,317,595.38 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | | 143,317,595.38 | -143,317,595.38 |
| Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 31,094,500.00 | -31,094,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 69,602,800.00 | -69,602,800.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 42,620,295.38 | -42,620,295.38 |
| НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,218,797.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 976,264.0 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 2,002.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 240,530.8 мянган төгрөгийн 5 зөрчил арилгах албан шаардлагыг тус тус хүргүүллээ.

***Залруулсан алдаа:***

Аудитаар нийт 976,264.0 мянган төгрөгийн 3 алдаа[1] илрүүлж аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

- Цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг үр дүнгийн тайланд 1,344.0 мянган төгрөгөөр зөрүүтэй;
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөг 974,435.2 мянган төгрөгөөр дутуу;
- Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй гарсан зардлыг 484.8 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасан.

***Залруулагдаагүй алдаа:***

### 3.1 Төлбөрийн акт

Аудитаар нийт 2,002.4 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснийг буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

- Сайнцагаан сумын 100 жилийн ойд зарцуулсан төсвийн зарцуулаагүй 2,002.4 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1-т /*Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална*/, 5.1.5-д /*хариуцлагатай байх*/, 45.2-т /*Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ*/ заасныг зөрчсөн.

*Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн актыг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон*

### 3.2 Албан шаардлага

Аудитаар 240,530.8 мянган төгрөгийн 5 зөрчил арилгах албан шаардлагыг хүргүүллээ. Үүнд:

- Өмнөх оны 706.0 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д /*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*/, 16.5.2-т /*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д /*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*/, мөн хуулийн 20.2.6-д /*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*/ заасныг;
- Сум байгуулагдсаны 100 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах төсвийг Монгол Улсын Засгийн газрын тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн 221,435.0 мянган

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төгрөгийг зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т /*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*/, мөн хуулийн 16.5.2-т /*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*/, Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолын 1–д /*Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоож, бөх, уяач, харваачдад төсвөөс олгох бай, шагналын жишиг хэмжээг хавсралт ёсоор шинэчлэн батлсугай*/ заасныг;

- Гадны машинаар ажил гүйцэтгүүлэхдээ гэрээ байгуулаагүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарцуулалт хийж, 4,247.8 мянган төгрөгийн төсвийн хөрөнгийг хяналтгүй зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т /*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*/, 20.2.3-т /*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*/ заасныг;
- Нягтлан бодогчийн ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр балансын урамшууллыг давхардуулан олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*/, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-т /*улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох*/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т /*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно*/ 15.1.3-т /*Хууль тогтоомжид заасанаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох*/, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь “/*Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна*/ заасныг
- Цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй этгээдээс тоног төхөөрөмж худалдан авсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 38.1-т /*Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна*/, 38.5-д /*Цахим дэлгүүрт нэг гүйцэтгэгч байгаа, эсхүл үнийн санал дуудахад үнийн санал ирээгүй бол захиалагч цахим дэлгүүрт бүртгэгдсэн хамгийн бага үнийн санал бүхий бараа, үйлчилгээг худалдан авч болно*/, Төрийн хэмнэлтийн хуулийн 14.4-т /*Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно*/ тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг заасан хугацаанд ирүүлэх*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг үр дүнгийн тайланд зөрүүтэй тайлагнасан. | 1 | 1,344.0 | | | 1 | 1,344.0 | 1 | 1,344.0 | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөг дутуу тайлагнасан. | 1 | 974,435.2 | | | 1 | 974,435.2 | 1 | 974,435.2 | | |
| Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй гарсан зардлыг илүү тайлагнасан. | 1 | 484.8 | | | 1 | 484.8 | 1 | 484.8 | | |
| **Дүн** | **3** | **976,264.0** | | | **3** | **976,264.0** | **3** | **976,264.0** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Өмнөх оны өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй. | 1 | 706.1 | | | 1 | 706.1 | | | | |
| Сум байгуулагдсаны 100 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах төсвийг Монгол Улсын Засгийн газрын тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн зарцуулсан. | 1 | 221,435.0 | | | 1 | 221,435.0 | | | | |
| Гадны машинаар ажил гүйцэтгүүлэхдээ гэрээ байгуулаагүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарцуулалт хийж, төсвийн хөрөнгийг хяналтгүй зарцуулсан. | 1 | 4,247.9 | | | 1 | 4,247.9 | | | | |
| Сайнцагаан сумын 100 жилийн ойд зарцуулсан төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй. | 1 | 2,002.4 | 1 | 2,002.4 | | | | | | |
| Нягтлан бодогчийн ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр балансын урамшууллыг давхардуулан олгосон. | 1 | 2,923.0 | | | 1 | 2,923.0 | | | | |
| | **5** | **231,314.3** | **1.00** | **2,002.4** | **4.00** | **229,311.9** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй этгээдээс тоног төхөөрөмж худалдан авсан. | 1 | 11,218.9 | | | 1 | 11,218.9 | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **11,218.9** | | | **1** | **11,218.9** | | |